



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
<http://www.mmhi.gov.mn>

2020.01.31 № 01/292
танай -ны № -т

Г МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

“Засгийн газрын үйл ажиллагааны
хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн
хяналт шинжилгээ, үнэлгээний
тайлан хүргүүлэх тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн Ул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан тус яамны эрхлэх асуудалд хамаарах 27 зорилтын арга хэмжээ, үүнээс дангаар хэрэгжүүлэх 8 арга хэмжээ, толгойлон хэрэгжүүлэх 46 арга хэмжээ, хамтран хэрэгжүүлэх 17 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тус яамны эрхлэх асуудалд хамааралтай 27 зорилт 73 арга хэмжээний биелэлт нь 2019 оны жилийн эцсийн байдлаар 85.07 хувийн хэрэгжилтэй байна.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2020.01.31-ний өдрийн хурлын тэмдэглэл 1 хуудас;
2. “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, хавсралтын хамт 59 хуудас.

Хавсралт⁶⁰ хуудастай.





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТӨМӨРЦӨЛӨТӨС

2020 оны 01 сарын 31 өдөр

Дүнээр

04

Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

"Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч Н.Баатар танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын зорилт, арга хэмжээ тусгагдсан бодлогын хоёр баримт бичигт хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэж, "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт, "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Үндэсний хөгжлийн газарт тус тус хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН НАРИЙН БЫНГИНИ
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

08 0034

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг хяналтанд авч, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, шийдвэр гаргах түвшний удирдлагуудыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг тус тус удирдлага болгов.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт санал зөвлөмж боловсруулсан.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 36 зорилтын 105 арга хэмжээ, үүнээс 76 арга хэмжээг толгойлон, 28 арга хэмжээг хамтран, 1 арга хэмжээг оролцогчоор хэрэгжүүлэхээр тусгагдсаныг хяналтанд авч сайдын 2017 оны A/22 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 27 зорилтын 73 арга хэмжээнээс дангаар хэрэгжүүлэх 8 арга хэмжээ, толгойлон хэрэгжүүлэх 46 арга хэмжээ, хамтран хэрэгжүүлэх 17 арга хэмжээ байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 73 арга хэмжээний 2019 оны жилийн эцсийн биелэлт **85.07 хувьтай**, үүнээс 51 арга хэмжээ “үр дүнтэй” 100 хувь, 9 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн” 70 хувь, 12 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” 40 хувь, 1 арга хэмжээ 0 хувийн хэрэгжилттэй байна (Хүснэгт 1).

Бодлогын зорилтоор нь авч үзвэл, эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын хүрээний 1 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 70.0 хувь, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын хүрээний 22 зорилтын 63 арга хэмжээний биелэлт 85.56 хувь, нийгмийн бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 40.0 хувь, байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 7 арга хэмжээний биелэлт 91.43 хувьтай дүгнэгдсэн.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГТГЭЛ
(2019 оны жилийн эцсийн байдлаар)**

ДД	Бодлого	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Үнэлгээ, хувь					Хүснэгт 1 Дун, хувь
				100	70	40	0	/-/	
1	Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого	1	2	1		1			70.00
2	Хоёр. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	22	63	44	9	9	1		85.56
3	Гурав. Нийгмийн бодлого	1	1			1			40.00
4	Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	3	7	6		1			91.43
	Нийт	27	73	51	9	12	1	0	85.07

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилtot түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай; илүү сайн тодорхойлох шаардлагатай, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй; шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан дараахь 13 арга хэмжээ байна. Үүнд:

- 1. “Эрчимжүүлэх шаардлагатай” 40 хувийн биелэлттэй 12 арга хэмжээ**
 - 1.24.3. Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх
 - 1.2. 2.11.3. Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх
 - 1.3. 2.61.2. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах
 - 1.4. 2.61. 3. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах
 - 1.5. 2.69. 5. Алтыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулах
 - 1.6. 2.72.4. Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах
 - 1.7. 2.72.5. Гангийн үйлдвэрийн өргөтгөл хийж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх
 - 1.8. 2.72.6. Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах

- 1.9. 2.92.2. Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх
- 1.10. 2.99.3. Хашаат цав, Тэвшийн.govийн орд газруудыг түшиглэн том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай байгуулах төслүүдийг эхлүүлэх
- 1.11. 3.2.33.10. Уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх
- 1.12. 4.2.3.2. Ус ашиглалтыг бүрэн тоолууржуулж, хаягдал бохир усыг цэвэрлэж, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

2. “Үр дүнгүй” 0 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ

- 2.1. 2.59.3. Монгол Улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх Агаарын геофизикийн судалгааны ажлын хүрээнд Ховд-1 төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлсэн 27 зорилт 73 арга хэмжээний хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 85.07 хувьтай байна.
2. Засгийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаадаа зорилтолт түвшинтэй уялдуулж, зарцуулсан хөрөнгө, эх үүсвэрийг тодорхой тайлагнахгүй нийтлэг дутагдал байна.
3. Зарим арга хэмжээний биелэлтийг өссөн дүнгээр тайлагнаагүй, албан хаагчид хариуцсан ажилдаа хайнга хандаж байна.
4. ХХААХҮЯ, /2.48.6. үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан байх ба, тус хөтөлбөрийн хүрээнд байгуулах үйлдвэрийн байршил, чиглэлд хүнд үйлдвэрийн төсөл, арга хэмжээ тусгагдаагүй болно/ Эрчим хүчний яам, Барилга хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цөмийн энергийн комиссын ажлын алба зэрэг бусад байгууллагын толгойлон хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнүүдийн биелэлт гаргахад бэрхшээлтэй байна.
5. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас хандаггүй байдал давтагдаж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ.

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу зорилтолт түвшин, баримт нотолгоо, зарцуулсан хөрөнгөний гүйцэтгэлд үндэслэн хүрсэн үр дүн, ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд мэргэжлийн өндөр түвшинд анхаарч, тайлан, мэдээг хугацаанд нь үнэн бодит тайлagnаж хэвших шаардлагатай байна.

2. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хэтийн болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр Засгийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах шаардлагатай байна.
3. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захирагааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 10.4 дэх “Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргаж болно.” гэж заасныг удирдлага болгон Засгийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг товч, тодорхой тайлagnаж, тухайн жил болон өмнөх жилүүдэд хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулга, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, сайдын тушаал зэрэг эрх зүйн баримт бичиг, фото зураг зэрэг нотлох баримтуудыг хавсаргаж байх шаардлагатай байна.
4. Яамны дотоод нэгжүүд, хэрэгжүүлэгч агентлаг бүрэн хэрэгжээгүй, хэрэгжилт удаашралтай арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангах, зорилтот түвшинд хүргэх, ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалт, ажлын уялдааг сайжруулах шаардлагатай байна.
5. Зарцуулсан хөрөнгө оруулалтын хэмжээг төлөвлөгдсөн дүнтэй нь харьцуулан гаргаж байх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хавсаргав.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр

Хянасан: ХШУДАГ-ЫН дарга

Г.Танхүү

Нэгтгэл хийж, ХШҮ-ний тайлан боловсруулсан:

ХШУДАГ-ЫН ахлах шинжээч

Н.Баатар /2020.01.30/

Геологи, уул уурхайн салбарын 40 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгсөн:

ХШУДАГ-ЫН мэргэжилтэн

Д.Батнайрамдал

Хүнд үйлдвэрийн салбарын 9 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгч, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулсан:

ХШУДАГ-ЫН ахлах мэргэжилтэн

Д.Болортuya

Газрын тосны салбарын 20 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгч, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулсан:

ХШУДАГ-ЫН шинжээч

Б.Баяржаргал